

МОНГОЛ, ЯПОНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА: ЯПОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

*Б.Сэржав**

1990 оноос хойш Монгол, Японы харилцаа шинэ шатанд дэвшин, улс төр, эдийн засаг, соёл боловсрол, хүмүүнлэгийн зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд өргөн цар хүрээг хамран өрнөн хөгжиж байгааг тэмдэглэн хэлэхэд нэн таатай байна.

Энэ хугацаанд Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Япон улс хамгийн гол түшиг тулгуур байсаар ирлээ. Мөн манай улсын эдийн засагт үүссэн гүнзгий хямрал, уналтыг зогсоох, эдийн засгийг тогтворжуулах, улмаар сэргээн хөгжүүлэх үндэс суурь тавихад шийдвэрлэх үүргийг Япон улс дангаараа гүйцэтгэж байна.

Өнөөдөр Монгол, Японы харилцаа иж бүрэн түншлэлийн хүрээнд өрнөн хөгжиж байна. Хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг бүх талыг хамран ярих боломжгүй тул би зөвхөн хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны өнөөгийн хүрсэн түвшин цаашдын чиг хандлагын талаар өөрийн санаа бодлыг та бүхэнтэй хуваалцах гэсэн юм.

Манай улс Япон улстай хамтын ажиллагааны хүрээнд эдийн засгийн солилцоог өргөтгөх, тухайлбал Япон улсын хөрөнгө оруулалтыг аль болохоор нэмэгдүүлэх, түүнийг эрчимжүүлэх асуудалд ихээхэн ач холбогдол өгдөг. 2004 оны байдлаар Япон улсаас манайд нийт 63 сая 600 мянга гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ. Өнөөгийн байдлаар манай улсад Япон улсын шууд хөрөнгө оруулалттай 170 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсад орсон гадаадын нийт хөрөнгө оруулалтын 6%-ийг Японы хөрөнгө оруулалт эзэлж байна.

Япон улсын хөрөнгө оруулалт голдуу хөнгөн аж үйлдвэр, мэдээлэл холбооны технологи, худалдаа нийтийн хоол, геологи уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, аялал жуулчлал, соёл, боловсрол, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт зэрэг салбарт төвлөрөн оржээ. Японы Сүмитомо, Иточү, Комацу компаниуд уул уурхайн салбарт, KDD, Сүмитомо компани харилцаа холбооны салбарт хөрөнгө оруулалт хийгээд байна. Монгол, Японы хамтарсан үйлдвэр үйлчилгээ, боловсрол, соёлын олон арван байгууллагууд үйл ажиллагаа нь тогтмолжиж олны танил боллоо. Эдгээр байгууллагууд нь манай улсын эдийн засаг ид хүндрэл бэрхшээлтэй байх үед үйл ажиллагаагаа эхэлж, хүн амын тодорхой хэсгийг ажлын байраар хангах, тэргүүний техник технологи, менежментийн арга барил, үйлчилгээний өндөр шаардлага, соёлыг нэвтрүүлэх, ажиллагсдад зах зээлийн нөхцөлд ажиллах мэдлэг, ур чадвар

* Б.Сэржав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

эзэмшүүлэх, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах, монгол түүхий эдийг бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргах зэргээр манай эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулж ирлээ.

Хоёр орон хөрөнгө оруулалт, эдийн засгийн үйл ажиллагааг өргөжүүлэхийн тулд 2002 онд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын засгийн газар Япон улсын засгийн газар хоорондын хэлэлцээр байгууллаа.

Сүүлийн үед Японы үйлдвэр компаниудын Монголд хөрөнгө оруулах сонирхол өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал өнгөрсөн 5-р сард Токио хотод болсон Монгол, Японы бизнес форумын үеэр Японы олон компани, корпорациуд ийм сонирхолтойгоо илэрхийллээ. Эдгээрээс Иточү компани уул уурхай, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, цаашид төмөр замд хамтран ажиллах, Мицүи компани Оюу толгой, Таван толгойн нүүрс зэрэг ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулахыг сонирхож байгаагаа илэрхийлсэн. Чухам энэ боломжийг алдахгүй байх явдал л манай улсын хувьд чухал болоод байна. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын орчноо улам сайжруулна гэсэн үг байх.

Япон улсын Гадаад хэргийн сайд хатагтай Кавагүчи Ёрико 2004 онд Монгол Улсад айлчлах үедээ МУИС дээр лекц уншиж Монгол Улсад Япон улсаас оруулах хөрөнгө оруулалттай холбогдуулан Монгол Улсын хувьд татварын давуу тогтолцоо, хууль зүйн болон захиргааны шинжтэй шат дамжлагын хялбаршуулалт, ил тод байдлыг сайжруулах зэрэг таатай нөхцлийг хэр зэрэг бүрдүүлэх вэ гэдэг нь чухал. Өөрөөр хэлбэл Монголын ирээдүйн эдийн засгийн хөгжил нь эдийн засгийн чөлөөт байдлыг баталгаажуулах, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхтэй холбоотой гэдгийг цохон тэмдэглэсэн юм.

Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын өнөөгийн орчин Японы хөрөнгө оруулагчид, бизнесийнхэнд хэрхэн ойлгогдож байгаа, тэдний хөрөнгө оруулах үйл ажиллагаанд чухам юу үгүйлэгдэж, юу саад болж байгааг дээрх үгнээс тодорхой ойлгогдож байна.

Хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах талаар олон төрлийн шийдвэр гаргаж, арга хэмжээ авсаар байгаа хэдий ч амьдрал дээр бодитойгоор хэрэгжих, үр ашгаа өгөх, хөрөнгө оруулалт хийж буй талынхаа сэтгэлд нь хүрэх талаар учир дутагдалтай байдгийг гадаадын хөрөнгө оруулагчид түүний дотор японы бизнесийнхэн олон жишээ татан өгүүлдэг. Түүнээс заримыг энд дурдвал юуны өмнө Монгол Улсын хөгжлийн дунд, урт хугацааны хөгжлийн стратеги бүрэн боловсрогдож, УИХ-аар батлагдан, ажил хэрэг болж эхлээгүй байгаа, улс орны эдийн засгийн хөгжлийн ирээдүйн чиг шугам, дүр төрхийг Монгол Улсын дотоодод болон гадаадад сурталчлан

тайлбарлах, өргөн олон нийтэд тодорхой ойлголт өгөх талаар бодит ажил хийгдэхгүй байгаа зэрэг нь гадаад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Тухайлбал уул уурхай, аялал жуулчлал зэргийг гадаадын хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбар хэмээн тодорхойлоод байгаа. Тэгвэл эдгээр салбаруудаа цаашид хэрхэн хөгжүүлэх гэж байна вэ гэдэг талаас нь хөрөнгө оруулагчид маш их судалж анхаардаг. Монголын ноолуурын салбар нь гадаадын хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбаруудын нэг, японы бизнесийнхний анхаарлыг зүй ёсоор татаж, өнөөг хүртэл Япон улсаас томоохон хэмжээний хөрөнгө оруулалтууд хийгдсэн, хамтын ажиллагааны тодорхой туршлага хуримтлагдсан манай улсын экспортын чиглэлийн гол салбар билээ. Тэгвэл энэ салбарт түүхий ноолуур нь гадагш их хэмжээгээр урсан гардаг, дотооддоо үйлдвэрлэл явуулж буй жижиг, дунд үйлдвэрээ хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжих төр засгийн тууштай бодлого байхгүй, ноолуурын түүхий эд үйлдвэрлэгч малчдын нийгмийн асуудлыг зөнд нь хаясан, байгаль цаг уур өөрчлөгдөж жил дараалан зуд турхан болж байгаа, ямаа их өссөнөөс сүргийн бүтцэд өөрчлөлт гарч, байгаль орчныг сүйтгэж байгаа, малчид тооны хойноос хөөцөлдөж, ноолуурын чанарыг бага анхаардаг болсон, ноолуурын ченж нарын болон гадаадын худалдан авагчдын элдэв ажиллагаанаас болж, ноолуурын гадаад зах зээл дээрх нэр хүнд, үнэ үнэлгээ буурч байгаа зэрэг бодит асуудал нь энэ салбарын ирээдүйн дүр төрхийг ихээхэн бүрхэгдүүлж байна. Энэ нь гадаадын түүний дотор Японы хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлэхэд хүргэж байна. Нөгөө талаар Японы Засгийн газрын буцалтгүй хөрөнгийн тусламжаар баригдаж ашиглалтанд орсон, Монгол Улсын экспортын тодорхой хэсгийг бүрдүүлсээр ирсэн Говь комбинатын хувьчлалын асуудал ч энд мөн шууд хамааралтай.

Түүнчлэн геологи, уул уурхайн салбарын хувьд дэд бүтэц хөгжөөгүй, зам тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн технологи, их барилгын салбарын хувьд стандартын шаардлага хангадаггүй, гадаадын ажилчдыг олноор нь оруулж ажиллуулдаг, тендерт элдэв хөндлөнгийн хүчин зүйлийн нөлөө их ордог гэх мэт олон асуудал Японы хөрөнгө оруулагчдын сэтгэлийг их зовоодог тухай миний бие олонтаа сонсож явлаа.

Төр засаг гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын эдийн засгийн өсөлт хөгжлийн нэг гол хүчин зүйл болгох бодлогыг нэгэнт баримталж байна. Нөгөө талаар улс орон хөрөнгө оруулагчаа сонгох биш, харин хөрөнгө оруулагчид өөрийнхөө хөрөнгийг хаана хэнд оруулахыгаа сонгодог цаг үе билээ. Тийм болохоор юуны өмнө гадаадын хөрөнгө оруулалтад саад болж буй дотоод шалтгааныг нарийн судалж, дотоод орчин нөхцөл байдлаа иж бүрнээр өөд татах явдал тулгамдаж байгаа мэт.

Гадаадын хөрөнгө оруулалт түүний дотор Японы хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж болох дотоодын зарим хүчин зүйлээс дурдвал:

1. Улс орны дотоодын тогтвортой байдлыг дурдаж болох юм. Тухайлбал, манай улсад засгийн эрх баригч нам сонгуулиар солигдсоноор төрийн байгууллага, улсын үйлдвэр, аж ахуй, соёлын байгууллагуудад ажиллагсад олноороо өөрчлөгдөж, өмнөх засгийн газрын үеийн дүрэм, журамд өөрчлөлт гардаг. Энэ нь ялангуяа Япон мэтийн улсын ч бай хувийн ч бай аж ахуйн байгууллагуудын албан тушаалтан онцгой тогтвортой ажилладаг орны хүмүүст ихээхэн ойлгомжгүй байдаг. Ийм байдлаас болж тэд манай улсад дорвитой хөрөнгө оруулалт хийхээ харзнах, тээнгэлзэх, цаашлаад үл итгэх, ирээдүйд чиглэсэн томоохон хөрөнгө оруулалт хийхээс болгоомжлох хандлага үүсдэг нь нууц биш.

2. Манай улсын хууль эрх зүйн орчин, татварын тогтолцоо, төрийн байгууллагуудын хүнд суртал, төрийн албан хаагчдын ёс зүй, ажил хэрэгч бус, авилгал хээл хахуульд автсан, хөшүүн хойрго байдал зэрэг нь Японы хөрөнгө оруулагч, хоёр орны хамтын ажиллагаанд оролцогч хэн бүхний эгдүүцэл дургүйцлийг төрүүлдэг. Ялангуяа хамтарсан аж ахуйн нэгж байгуулах, хөрөнгө оруулж үйл ажиллагаа явуулахад элдэв чирэгдэл ихтэй, цаг хугацаа их шаарддаг, татвар төлбөрийг тогтмол нэхдэг, гаалийнхан нь хүнд сурталтай, ил тод биш, холбогдох байгууллага тушаалтнууд хээл хахуульд дуртай, албан үүргээсээ илүү амин хувийн эрх ашгаа ямагт боддог нь гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх байтугай харин ч буцаж гарах буруу зуршил тогтоход хүргээд байна.

3. Бизнесийн үйл ажиллагаа явуулж буй хувь иргэдийн ажил хэрэгч байдал, зан чанар, харилцааны соёл, боловсрол, хэлний саад бэрхшээл бусадтай хамтран ажиллах бизнесийн болон мэрэгжлийн ур чадварын асуудал ч энд их үүрэгтэй байдаг ажээ. Эдийн засаг нь нээлттэй чөлөөтэй болсон, ажилгүйдэл ихтэй, ард түмнийх нь амьдрал ядмаг дорой байгаа энэ үед нь хөрөнгө оруулж үйл ажиллагаа явуулъя, аль аль талдаа ашигтай хамтран ажиллая хэмээн найрсаг сэтгэл өвөрлөж, бэрхшээлийг ойлгож байвч зориглон ирсэн нэг бус япон хүнийг элдвээр чирэгдүүлэн бизнесийн үйл ажиллагаагаа явуулах байтугай эд хөрөнгө, санаа сэтгэлийн хүнд байдалд оруулаад буцааж байсан жишээ манай өдөр тутмын сонин хэвлэлд нэг бус удаа гарч байсан билээ. Зөвхөн түр зуурын хувийн ашиг хонжоо хайсан зарим цөөн хүмүүсийн бусармаг үйл ажил нь улс орны нэрийг гутаасан, нийгэмд холын уршиг дагавартай, тэвчишгүй ёс бус зүйл гэдгийг Монгол Улсын иргэн бүхэн ялангуяа залуу үеийнхэнд сайтар ойлгуулж хүмүүсийнхээ ёс суртахууны хүмүүжлийг сайжруулах, зах зээлийн эдийн засгийн мэдлэг ур чадвар эзэмшүүлэхийн тулд өнөөгийн боловсролын тогтолцоог үндсээр нь өөрчлөх талаар анхааран ажиллах цаг болсон мэт санагдана.

Эцэст нь Монгол Улсад зах зээлийн эдийн засгийн өнөөгийн нөхцөлд Япон улсаас хөрөнгө оруулалт авахын давуу талыг дараах хэдэн зүйлээр тодруулан хэлж болох бизээ.

1. Япон улсын үйлдвэрлэгчид нь гадаад хөрөнгө оруулалт хийх талаар хуримтлуулсан туршлагынхаа хувьд бусад улсаас илүү гэж үзэж болно. 1970-аад оноос тухайлбал, Азийн барс-Өмнөд Солонгос, Сингапур, Гонконг, Тайвань зэрэг орон, бүс нутаг, 80-аад оноос АСЕАН-ы орнууд, 80-аад оны сүүл 90-ээд оноос Азийн социалист орнууд-Хятад, Вьетнам зэрэг улсууд эдийн засгаа эрчимтэй хөгжүүлж чадсаны гол эх сурвалж нь Японы туршлага, хөрөнгө оруулалт, тусламжийн хүчин зүйлтэй салшгүй холбоотой билээ. Хэдийгээр нийгэм, эдийн засгийн үндэс суурь ялгаатай ч эдгээр орнуудад Япон улсын хөрөнгө оруулалтыг ямар хэлбэр, аргаар, яаж хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрч чадсан талаар судлан үзэх нь бидэнд ашиг тусаа өгөх болно. Өөрөөр хэлбэл хэдэн арван жилийн өмнөөс гадаадад хөрөнгө оруулалт хийж, хөрөнгийг хүлээн авсан орнууд нь эдийн засгийн хөгжлийн тодорхой түвшинд нэгэнт хүрээд байгаа бодит жишээг харгалзан Японы хөрөнгө оруулалтыг илүү чухалчлан үзэх үндэслэл бий.

2. Ер нь гадаад хөрөнгө оруулалтыг дагаж шинэ технологи, шинэ мэдлэг орж ирдэг. Тэгвэл шинжлэх ухаан, техникийн дэвшил, технологийн хөгжлөөр Азидаа төдийгүй дэлхийд тэргүүн байранд ороод удаж байгаа Япон улсын шууд хөрөнгө оруулалт нь манай улсын эдийн засгийн өсөлт хөгжлийн нэгэн гадаад чухал хүчин зүйл мөн. Япон улсын хөрөнгө оруулалттай үйлдвэр аж ахуйн газар олноор байгуулагдах нь манай улсын эдийн засгийн шинэчлэл, технологийн дэвшил, ажиллах хүчний мэдлэг боловсрол, бизнес эрхлэх ур чадвар, менежмент, ажлын дэг журам, аж ахуйн газрын орчны өөрчлөлт шинэчлэлтээс эхлээд олон талын ач холбогдлоороо манайд хөрөнгө оруулалт хийж буй бусад улсынхаас давуу байгаа билээ. Глобалчлалын эриний шинэ эдийн засаг мэдлэг оюунд суурилах болоод байгааг ч энд харгалзан үзэх ёстой.

3. Одоо манай улсад үйлдвэрийн газрын, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн газрын хөдөлмөрийн эрүүл ахуй, хүрээлэн буй байгаль орчинд нөлөөлөх асуудал онцгой анхаарал татаж байна. Монгол Улс өнөөдөр хөрөнгө оруулалт болон бусад салбарт нэн ялангуяа уул уурхайн салбарт голланд өвчинд гүнзгий нэрвэгдээд байна. Хэзээ ч үл нөхөн төлжих ашигт малтмалыг экологийн тэнцвэрийг үл харгалзан зөвхөн ашгийн төлөө цөллөж байна. Энэ нь ард түмний амьдрал эдийн засгийн өсөлтөд үзүүлэх үр нөлөө ч бага байна. Үүнийг л голланд өвчин гэдэг шүү дээ. Тэгвэл Япон улс орчин үеийн шинэ өндөр технологийг бий болгох явцдаа экологийн цэвэр байдлыг хадгалан байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх асуудлыг байнга

анхаарч технологио сайжруулан тэргүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж чадсан орон. Тиймээс дэлхий дахинаар экологийн тэнцвэрийг хадгалах асуудал яригдаж байгаа өнөө үед гадаадын хөрөнгө оруулж л байвал хамаагүй гэсэн голланд өвчинд нэрвэгдсэн харалган бодлоор биш, харин цаашдын үр дагавар сөрөг уршгийг урьдаас сайтар төлөвлөж, Япон мэтийн тэргүүний эдийн засагтай улсаас оруулах хөрөнгө оруулалтад түлхүү анхаарал хандуулах нь зүйтэй болов уу. Ингэвэл бид цаг алдалгүй голланд өвчинөөс илааршиж мэдэх юм.

4. Манай улсын эдийн засгийн цаашдын тогтвортой өсөлтөд уул уурхай, ашигт малтмалын салбарыг эс тооцвол хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, ноолуур болон аялал жуулчлалын салбарын хөгжил чухал нөлөөтэй байгаа өнөө үед эдгээр салбарын үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд Япон шиг тэргүүний хөгжилтэй улсын хөрөнгө оруулалт шийдвэрлэх ач холбогдолтой гэж бодож байна. Өөрөөр хэлбэл экспортын чиглэлийн эдгээр салбарын бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх асуудал юм. Зэс болон байгалийн бусад эрдэс баялагт аль болох гүн боловсруулалт хийх, ноолуурыг дотооддоо бүрэн боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох чиглэлд Япон улсын хөрөнгө оруулалт илүү үр дүнд хүрнэ гэж үзэх үндэстэй.

Япон улсын хөрөнгө оруулалтын давуу талыг энэ мэт жишээгээр хэдэн арвыг ч дурьдаж болохоор байна.

Товчоор хэлэхэд Японы хөрөнгө оруулалт нь манай улсын дотоодын хөрөнгийн эх үүсвэрийн дутагдлыг нөхөх, эдийн засгийн өсөлт хөгжлийг хурдасгах, зах зээлийн тогтолцооны нөхцөлд аж ахуйг эрхлэн хөтлөх, удирдлагын арга барилыг боловсронгуй болгох, орчин үеийн шинэ мэдлэг, шинэ техник технологи, ноу хау нэвтрүүлэх, ажилгүйдлийг багасгах, экспортыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээл дээр бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх гэх мэт олон талын шийдвэрлэх ач холбогдолтой гадаад хүчин зүйлийн нэг болоод байна.

Энд тэмдэглэхэд хөрөнгө оруулалтыг харилцан бие биеэ сайн танин мэдээгүй тохиолдолд хэрэгжүүлэх гэдэг үл биелэх асуудал. Тиймээс ч хоёр орны жирийн ард түмний дунд бие биеийг сурталчлах, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол явуулах шаардлагатай.

Эцэст нь тэмдэглэхэд манай улс өнөөг хүртэл Япон улсын зүгээс их хэмжээний тусламжийг /1991 оноос 2004 оныг хүртэлх 13 жилийн хугацаанд нийт 128 тэрбум 300 сая иен, ойролцоогоор 10 тэрбум 170 сая орчим ам.доллар/ хүлээн авлаа. Энэ нь манай улсад үзүүлсэн 2 талын нийт тусламжийн 70 гаруй хувьтай тэнцэж байна. Япон улс Монгол Улсыг дэмжих, зээл тусламж үзүүлэх бодлогоо цаашид ч өөрчлөхгүй гэдгээ удаа дараа мэдэгдэж байна.

Япон улсын Засгийн газар өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн хамтын ажиллагааны туршлага манай улсын эдийн засгийн өнөөгийн бодит байдлыг харгалзан үзэж ирэх 5 жилд Японы талын тусламжийг аль салбарт түлхүү үзүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон “Монголд зориулсан тусламжийн тусгай хөтөлбөрийг” боловсруулж хоёр улсын Засгийн газрын төвшинд хэлэлцэн тогтож хэрэгжүүлж эхлэх гэж байна.

Япон улсын зээл тусламж нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн цаашдын үндэс суурийг баттай тавьж, улмаар Япон улсын хөрөнгө оруулалт гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх суурь нөхцлийг бүрдүүлж байна гэж ойлгож байна.

Эцэст нь тэмдэглэхэд өнөөдөр бид глобалчлал хэмээх шинэ цаг үед амьдарч, эд юм, хүн, хөрөнгө мөнгө цаашлаад мэдээлэл, үйлчилгээ дэлхий дахинаар чөлөөтэй урсаж байна. Энэ хэмжээгээр Монгол, Япон улсын хоорондын зай ч улам ойртож байна. Ийм цаг үед Зүүн Ази хэмээх нэгэн бүс нутагт хамт оршиж, зах зээлийн эдийн засаг, ардчиллын үнэт зүйлсийг хамт өмчилж байгаа болохоор Монгол, Японы харилцаа хамтын ажиллагаа саяын миний товч хөндсөн хөрөнгө оруулалтаар зогсохгүй бүх салбарт эрчимтэй хөгжиж “иж бүрэн түншлэлийн харилцаа” саадгүй хэрэгжинэ хэмээн итгэж найдаж байна.